

Аймгийн Засаг даргын 2023 оны... дугаар
сарын ...-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт



ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ БОЛОН БАКТЕРЖУУЛСАН
БУДААНЫ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Сумын нэр	Сумаас олгосон санхүүжилт (мянган төгрөг)	Сумаас авах бактержуулсан будаа (мянган тонн)-оор	Улсын төсвөөс хувиарлах бактержуулсан будаа (мянган тонн)	Тэмцэх талбайн хэмжээ (мянган га-аар)
1	Есөнзүйл	13,0	2,0	1,5	2,3
2	Өлзийт	18,0	2,7	1,5	2,8
3	Зүүнбаян-Улаан	15,0	2,3	1,5	2,5
4	Сант	8,0	1,2	1,5	1,8
5	Тарагт	26,0	4,0	3	4,6
6	Төгрөг	13,0	2,0	1,5	2,3
7	Уянга	5,05	0,77	1	1,1
8	Хайрхандулаан	65,0	10,0	4	9,3
9	Хужирт	24,0	4,1	3	4,4
10	Хархорин	72,0	11,0	6	11,3
11	Гучин-Ус	-	-	2,5	1,6
	Нийт дүн	259,05	40,07	27	44,0

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар

2/175

Арвайхээр сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” А/143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус, Сант, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт, Хархорин сумдын 44.0 мянган га бэлчээрт микробиологийн аргаар мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх талбайн хэмжээ болон бактержуулсан будааны зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

3.Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хувцас, шаардлагатай техник хэрэгслээр хангаж, сургалт явуулах, бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль журмын дагуу ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажлыг эхлүүлж, сумын Засаг дарга нартай гэрээ байгуулж, мэрэгчтэй тэмцэх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0320

D:My Doc. Zahiramj. Zasag darga